

11

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАТВАРЫН ОРЧИН

Р.Гансүх

Гадаадын хөрөнгө оруулалтын хөдлөшгүй, гурван үндсэн зарчим байдаг. Энэ нь **нэгд**, хөрөнгө оруулах сонирхлыг төрүүлэх, **хоёрт**, орж ирсэн хөрөнгийг хамгаалах туслах, **гуравт**, буцааж гаргахгүй байх аятай нөхцлийг бүрдүүлэх асуудал чухал байдаг. Судалгаанаас үзэхэд дээрх үндсэн зарчмуудын хөрөнгө оруулах сонирхлыг төрүүлэх, нэгэнт орж ирсэн хөрөнгийг буцааж гаргахгүй байх нөхцлүүд нь тухайн оронд мөрдөж байгаа татварын хэмжээ, хөрөнгө оруулагчдад үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, урамшууллаас ихээхэн шалтгаалдаг. Хөрөнгө оруулагч компани, пүүсүүд хөрөнгө хүсэгч орны татварын хууль тогтоомжийн шинжилгээ тухайлбал, тухайн орны татварын хэв шинж, хувь хэмжээ, тогтвортой мөрдөгдөх нөхцөл, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт бусад оронтой татварын хэлэлцээр байгаа эсэх талаар судалгаа явуулдаг.

Дээрхтэй холбоотой баримт дурдахад (тухайн үед мөрдөгдөж байсан) 1998 оны 9-р сараас эхлэн хамтарсан аж ахуйн нэгжийн олборлосон алтанд 10 хувийн экспортын татвар ногдуулах болсон нь Монголд уул уурхайн салбарт үйл ажиллагаагаа эрчимтэй эхлээд байсан дэлхийд нэртэй Австралийн үндэстэн дамнасан "BHP", Английн "RTZ" зэрэг компаниуд ажлаа зогсоосон. Мөн түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалттай оёдлын үйлдвэрүүдийн технологийн түүхий эдийн хуулиар чөлөөлөгдөх ёстой татварыг 5-18 хүртэл хувиар тогтоох шийдвэрийг удаа дараа гаргаж байсан нь эдгээр үйлдвэрүүдийн үйл ажиллагааг ямар нэгэн хугацаагаар саатуулж, улмаар тэнд ажиллаж байсан Монгол ажилчдын эрх хохирч байсан баримт ч бий.

Дэлхийн банкнаас хийсэн судалгаанаас үзэхэд дотоодын нийт бүтээгдэхүүнд татварын орлогын эзлэх хэмжээ 1995-1998 оны баримтаар Африкийн орнуудад 8.4, Азид 14.0, Ойрхи Дорнодод 11.0, Төв, Зүүн болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудад 24.6 хувь байжээ. Харин энэ үзүүлэлт манай улсад 2000 онд 24.9 байсан бол 2002 онд 29.0 хувь болж өссөн байна. Энэ нь хөгжиж буй болон хөгжингүй орнуудын дундаж үзүүлэлтээс харьцангуй их боловч эдийн засаг, нийгмийн хөгжил, тулгарч буй бэрхшээл нь дээрх орнуудад адил байна гэж үздэг.

Манай улсад аж ахуйн нэгж байгууллагын орлогод ногдуулах албан татварын хувь хэмжээ, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг ерөнхийд нь дараах схемээр тоймлон харж болно.

Гадаадын хөрөнгө оруулалттай хамтарсан аж ахуйн нэгжийн орлогод ногдох татварын хувь хэмжээ, хөнгөлөлт чөлөөлөлт

ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР

Орлогод ногдох татварын хувь хэмжээ 15-40 хувь

Цахилгаан дулааны станц, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, авто, төмөр зам, агаарын тээврийн болон инженерийн барилга байгууламж, телекоммуникацийн сүлжээний салбар

Эхний 10 жилд бүрэн чөлөөлнө.

Үнэт металлаас бусад эрдэсийн түүхий эд, нефть, хатуу түлш олборлох, боловсруулах металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроник

Эхний 5 жилд бүрэн чөлөөлнө.

Дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 50-иас дээш хувийг экспортлож байвал ОАТ-аас чөлөөлнө.

Эхний 3 жилд бүрэн чөлөөлнө.

Дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

БУСАД ТАТВАР:

- НӨАТ – 15 хувь
- Гаалийн татвар – 5 хувь

Тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа бол үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, угсрах, суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмд Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн татвар ногдуулахгүй.

Дээр заасан татварын заалтуудаар тухайлбал, 1997-1999 оны хооронд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хэчнээн хэмжээний татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хэдэн аж ахуйн нэгж, компани эдэлснийг харъя.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдэд эдлүүлсэн хөнгөлөлт, чөлөөлөлт (мян.төг)

№	Хуулийн заалт	Аж ахуйн нэгжийн тоо			Хөнгөлөлт			Чөлөөлөлт		
		1997	1998	1999	1997	1998	1999	1997	1998	1999
1	ААНОАТХ 7-5-1	8	7	2	-	-	-	46830.6	1275415.7	44878.4
2	ААНОАТХ 7-5-2	8	7	10	-	-	-	218500.2	198252.3	2403125.3
3	ААНОАТХ 7-5-2	-	-	1	-	-	61326.5	-	-	-
4	ААНОАТХ 7-6	4	4	5	9018.2	35762.9	137812.0	-	-	-
5	ААНОАТХ 7-6	9	12	31	-	-	-	358410.4	273121.8	866070.5
6	ААНОАТХ 7-8	-	1	-	-	36026.3	-	-	-	-
7	ААНОАТХ 7-11	-	1	-	-	22857.8	-	-	-	-
Нийт дүн		29	32	49	9018.2	94647.0	199138.5	1045218.0	1746789.8	3318074.2

Эх сурвалж: ГХГХГ-ын тоо материалыг ашиглан хийсэн тооцоо

Гэсэн хэдий ч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдээс улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа нийт татварын хэмжээ жилээс жилд өсөж байна. Тухайлбал, ГХОААН-ийн төлсөн татварыг 1996-1999 оны хооронд авч үзвэл нийтдээ нийслэлийн төсөвт оруулсан татварын хэмжээ 97.7 млрд төгрөг болсны 14.6 хувь буюу 14.3 млрд төгрөгийг ГХОААН-үүдийн татвар эзэлж байгаа бөгөөд 1996 оныг 1999 онтой харьцуулж үзэхэд 8.3 хувиар өссөн байна. Үндсэндээ нийслэлийн төсвийн орлогын 39.4 хувийг ГХОААН-ийн татвар эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн нийслэлийн төсөвт оруулсан татварын хэмжээ (мян.төг)

	1996	1997	1998	1999	2001
Нийслэлийн төсөвт төлсөн аж ахуйн нэгжийн нийт татвар хэмжээ.	15820085.4	22280189.3	27468829.7	31865524.2	
Үүнээс:					
ГХОААН-үүдийн төлсөн татвар	971200.0	1944508.0	3902577.6	7586962.0	
Нийслэлийн төсөвт харьцуулсан хувь	6.14	8.73	14.2	23.8	39.4
ГХОААН-д үзүүлсэн татварын хөнгөлөлт		9018.2	94647.0	199193.0	
Нийслэлийн төсөвт харьцуулсан хувь		0.04	0.34	0.62	
ГХОААН-д үзүүлсэн чөлөөлөлт		1045218.2	1746789.8	3200390.0	1500000.0
Нийслэлийн төсөвтэй харьцуулсан хувь		4.69	6.36	10.67	
Нийт хөнгөлөлт, чөлөөлөлт		1054236.4	1841436.8	3399583.0	6800000.0
Нийслэлийн төсөвт харьцуулсан хувь		4.73	6.70	10.67	

Эх сурвалж: Нийслэлийн татварын албанаас гаргасан тоо, материалыг үндэслэн гаргаж.

Монгол улсад үйлчилж байгаа татварын орчин нь гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эерэг тааламжтай нөхцлийг бүрдүүлж байгаа юм. 1993 онд баталсан "Гадаадын хөрөнгө оруулалтын тухай" хуульд зааснаар хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүдийн эдлэх ёстой хөнгөлөлт, чөлөөлөлтийн хүрээ нь үндсэндээ үйлдвэрлэл үйлчилгээний бүх салбарыг хамарч байсан боловч үр өгөөж нь төдийлөн хангалтгүй, ихээхэн материал түүхий эдийг гаднаас авч захиалагчийн материалаар бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаадад гаргадаг оёдол, нэхмэл, сүлжмэл эдлэлийн үйлдвэрлэл эрхэлдэг хөрөнгө оруулагч нараас бүрдэж манай улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж чадаагүйн зэрэгцээ Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн бус орнуудын хувьд экспортын татвараас зайлсхийхэд нь тааламжтай нөхцлийг бүрдүүлж байсан. Иймд бид цаашид хөрөнгө оруулагч орнуудын ДХБ-ын гишүүн мөн эсэхэд судалгаа хийж анхаарч ажиллах ч шаардлагатай болж байна.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн Монгол улсын Засгийн газрын 2001 оны 140 дугаар тогтоолоор гадаадын хөрөнгө оруулах тэргүүлэх ач холбогдол бүхий доорх салбаруудын жагсаалтыг батлан гаргасан. Үүнд:

- Хөдөө аж ахуй (газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй)
- Олборлох үйлдвэрлэл (нүүрс, газрын тос, төмөрлөг болон төмөрлөг бус ашигт малтмалын олборлолт)
- Боловсруулах үйлдвэрлэл (хүнсний бүтээгдэхүүн, нэхмэл эдлэл, арьс шир, модон эдлэл, химийн бүтээгдэхүүн, барилгын материал, төмөрлөгийн үйлдвэрлэл, хоёрдогч түүхий эд)
- Дэд бүтцийн салбар (цахилгаан, уур ус үйлдвэрлэл, барилга, нефть, хий дамжуулах хоолой барих) гэсэн үндсэн 4 чиглэлийн салбараас бүрдэж байна.

Үүнтэй уялдаад СЭЗЯ, ҮХЯ-ны сайдын хамтарсан тушаалаар тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт хөрөнгө оруулж буй гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн технологийн зориулалтаар ашиглах тоног төхөөрөмжийн жагсаалтыг баталж мөрдүүлэх болсон нь эдгээр салбарт ажиллаж байгаа гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд эрх зүйн тааламжтай орчинг бий болгож тэдний талархалыг хүлээсэн юм.

Манай оронд болж өнгөрсөн гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтаас харахад хөрөнгө оруулагчдын гочлон хөндөж тавьсан, шүүмжлэлтэй хандаж байсан асуудлууд мөн л татварын тогтолцооны тогтвортой байдал, татвар ногдуулах орлогын хэмжээ, гааль, татварын хяналт шалгалт их байгаа талаар яригдаж байсан. Эндээс үзэхэд Монголд гадаадын хөрөнгө оруулалтын орчин тэр дундаа хууль, эрх зүйн орчин тогтвортой байх нь хамгаас чухал гэж дүгнэж болохоор байна.